



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,

Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2026.01.30 № 9/585
танай _____-ны № _____-т

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН С.ЭРДЭНЭБОЛД ТАНАА**

“Хүний амьд явах эрхийн хэрэгжилтийн тухай”
таны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн
53 дугаартай асуулгыг хүлээн авч танилцан
холбогдох мэдээллийг асуулга тус бүрээр гаргаж,
хавсралтаар хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт 8. хуудастай.

Хүндэтгэсэн,



Б.ЭНХБАЯР

ХЗДХЯ-ны А5
15264079

Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн
1/585 дугаар албаны бичгийн хавсралт

“ХҮНИЙ АМЬД ЯВАХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТУХАЙ”
(Дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд)

1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжоор хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах тэр дундаа эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх талаар алба хаагчдад мэдлэг, ойлголт, хандлагыг төлөвшүүлэх зорилгоор 2026 оны 01 дүгээр сараас эхлэн Дотоодын цэргийн байгууллага нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комисс, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Үндэсний ажиллагаатай хамтран 4 багц, 32 цагийн сургалтын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүний эрхийн мэдлэг олгох зорилгоор Дотоодын цэргийн анги, тусгай салбарын цэргийн ротын офицер, ахлагч болон хугацаат цэргийн алба хаагчдад цэргийн дүрмийн бус харилцаа, хүний эрхийн ойлголт, төрийн албан хаагчийн ёс зүй, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, дэлхийн улс орнуудын гадаад, дотоод аюулгүй байдлын талаар сургалтыг Дотоодын цэргийн штаб, анги, тусгай салбарын бие бүрэлдэхүүнд зохион байгуулсан.

Дотоодын цэргийн 05, 805, 810 дугаар ангиудын гадна болон дотор байршуулсан теле камерыг Монгол Улсын теле камерын системийн MNS 6423:2019 техникийн ерөнхий шаардлагын 6.2.1 дэх хэсэгт нийцүүлэх ажлын хүрээнд “Теле хяналтын камер болон түүний дагалдах техник хэрэгслийн үзлэг, үйлчилгээ хийх график, төлөвлөгөө, удирдамж”-ийн дагуу хугацаат цэрэг байрлаж байгаа теле хяналтын камеруудыг нэмэгдүүлэх ажлыг 2023, 2024 онуудад үе шаттайгаар зохион байгуулсан.

Энэхүү ажлын хүрээнд 2023 онд 05 дугаар ангийн хугацаат цэргийн байранд нийт 14 ширхэг /дотор 11, гадна 1, хөдөлгөөнт 1/, 805 дугаар ангид нийт 15 ширхэг /дотор 13, гадна 2/ нийт 29 ширхэг теле хяналтын камерыг тус тус суурилуулсан.

Мөн 2024 онд дээрх 2 ангийн байрлалд дахин үзлэг, хяналтыг хийж камерын хяналтад ороогүй, хүрэлцээгүй цэгүүдийг тодотгож учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчил, үүссэн нөхцөл байдлыг бичлэгээр нотлох, баримтжуулах, алба хаагчийн буруутай эсэх үйл ажиллагааг тогтоох, барилга байгууламжийн аюулгүй байдлыг хангах ач холбогдолтой тул нэмэлтээр 05 дугаар ангид 23, 805 дугаар ангид 22 ширхэг теле хяналтын камерыг суурилуулсан.

2026 оны 01 дүгээр сарын 06-08-ны өдрүүдэд үзлэг зохион байгуулж, камерын хяналтад авагдаагүй нэн тэргүүнд камержуулах шаардлагатай бүс, цэгүүдийг тодорхойлж, гадна болон дотор зориулалтын камер, сүлжээ, ханан дэлгэцийн видео удирдлагын системийг нэвтрүүлэх, хяналтыг сайжруулах техник хэрэгсэл, дагалдах материалын судалгааг гарган камерын хяналтад бүрэн оруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын "Ажлын хэсэг байгуулж, удирдамж батлах тухай" 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/176 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн Дотоодын цэргийн штаб, харьяа анги, тусгай салбарын үйл ажиллагаанд явуулсан хяналт шалгалтын тайланд дурдагдсан дүгнэлт, саналыг хэрэгжүүлэх зорилгоор Дотоодын цэргийн командлагчид ажлын чиглэлийг хүргүүлсэн.

Дотоодын цэргийн байгууллагаас дээрх чиглэлийг хэрэгжүүлэх, цэргийн албанд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлд дүгнэлт хийж, түүнээс урьдчилан сэргийлэх, цэргийн дүрмийн бус харьцааг илрүүлэх, бүртгэх, таслан зогсоох арга хэмжээ авч, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын тоог нэмэгдүүлэхээр төлөвлөн, биелэлтийг ханган ажиллаж байна.

2./Дотоодын цэргийн байгууллагаас амь хохирсон, эрүүл мэндээрээ хохирсон, цэргийн дүрмийн бус харьцаа гаргасан алба хаагчдын шалтгаан нөхцөл зэрэг холбогдох мэдээллийг хавсаргав./

3.Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу Дотоодын цэргийн штабаас харьяа анги, тусгай салбарын үйл ажиллагаанд хяналт шалгалтыг явуулж, цэргийн дүрмийн бус харилцааны 3 зөрчлийг дотоод хяналтаар илрүүлж, цахим орчинд нийтлэгдсэн 1 мэдээлэлд албаны шалгалт явуулан 8 алба хаагчид Төрийн албаны тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 180 дугаар зарлигийн дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан "Цэргийн сахилгын дүрэм"-д заасан сахилгын шийтгэл ногдуулж, харьяаллын дагуу нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад шалгуулахаар шилжүүлсэн.

Дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдаас албан үүрэг гүйцэтгэж байхдаа амь хохирсон 3, өвчний улмаас нас барсан 4, нийт 7 алба хаагчийн ар гэрт Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 4, 20 дугаар зүйлийн 1 хэсэгт заасан нэг удаагийн тэтгэмжийг олгосон.

Цаашид цэргийн албанд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хугацаат цэргийн алба хаагчдын сахилга, ёс зүйг сайжруулах зорилгоор "Цэргийн соёлыг төлөвшүүлэх хөтөлбөр"-ийг боловсруулахаар холбогдох тооцоо, судалгааг хийж байна.

4.Дотоодын цэргийн алба хаагчийн ёс зүйн дүрэмд хүний эрхийн зарчим, хэм хэмжээнд нийцүүлж, хүний нэр төрийг гутаан доромжлох, хүнлэг бусаар харьцахыг хориглосон зохицуулалтыг тусган, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.7 дахь хэсэгт заасны дагуу төслийг Монгол Улсын Ёс зүйн хороонд хүргүүлэн хянуулж, Дотоодын цэргийн командлагчийн 2024 оны А/41 дүгээр тушаалаар баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Дотоодын цэргийн алба хаагч, ажилтны сэтгэл зүйн байдлыг судлан оношилж, сэтгэл зүйн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, тэдний дунд сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэх, бүтээлч, зөв хандлагыг төлөвшүүлэх, албан үүргээ хэвийн гүйцэтгэхэд нь сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлж, удирдлагыг сэтгэл зүйн мэдээллээр хангах зорилгоор Дотоодын цэргийн штабт эрүүл мэнд, сэтгэл зүйн ажил хариуцсан 1 ахлах мэргэжилтэн, Дотоодын цэргийн 05, 805, 809, 816 дугаар ангиудад тус бүр 1 сэтгэл зүйчийн орон тоог нэмсэн.

Хугацаат цэргийн алба хаагчийн алба хаах орчин нөхцөл, тэдний нас, сэтгэхүйн онцлогт тохирсон зан үйлийн нарийн шинжилгээ хийхэд тохиромжтой сэтгэл зүйн судалгааны арга зүй байхгүй, байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх журам, зааваргүй байсан ба ялангуяа хугацаат цэргийн албанд татагдан ирж байгаа залуусын сэтгэл зүйн бэлэн байдлыг нарийвчлан оношлох хэрэгцээ шаардлага үүссэн бөгөөд "Алба хаагчид сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх (код 1/111 журам)" -ыг Дотоодын цэргийн командлагчийн 2023 оны А/20 дугаар батлуулж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Мөн цэргийн албанд татагдан ирж буй иргэдийн сэтгэл зүйн бэлэн байдлыг 4 хүчин зүйлийн хүрээнд буюу тухайн бие хүний дасан зохицох чадвар, эрсдэлт зан үйл, стрессийн түвшин, сэтгэл хөдлөлийг шуурхай оношлох зорилгоор Монгол Улсын Боловсролын Их Сургуультай хамтран "Сэтгэл зүйн бэлэн байдлыг оношлох судалгааны арга зүйн төсөл" -ийг 5.000.000 (таван сая) төгрөгийн зардлаар амжилттай хэрэгжүүлж, найдвартай болон баталгаат чанарыг үнэлэх шалгуур үзүүлэлтийн дагуу статистик программ хангамжийн тусламжтайгаар үнэлэхэд чанар өндөр үнэлэгдэж, 388 хугацаат цэргийн алба хаагчаас судалгаа авч, үр дүнг боловсруулахад хүлээлтэд нийцсэн үр дүнг үзүүлсэн.

Улмаар хугацаат цэргийн алба хаагчдын сэтгэл зүйн бэлэн байдлыг оношлох судалгааны арга зүйг цахим программ болгон төрийн цэргийн байгууллагуудын хэмжээнд анх удаа нэвтрүүлж, Монгол Улсын Оюуны өмчийн газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/148 дугаар тушаалаар бүртгүүлж, 16310 дугаартай зохиогчийн эрхийн гэрчилгээг хүлээн авч, үйл ажиллагаанд ашиглаж байна.

Цахим программыг 2024 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагаас эхлэн ашиглаж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар "Цэрэг татлагын байр" -нд ирсэн 1376 иргэний сэтгэл зүйн байдалд нарийн шинжилгээ хийн, сэтгэл зүйн тэнцвэрт байдал хангаагүй 13 иргэнийг богино хугацаанд илрүүлэн, холбогдох эрүүл мэндийн байгууллагад шилжүүлж ажилласнаар хугацаат цэргийн алба хаагчдаас эрсдэлт үйлдэл гараагүй, үр дүнтэй ажил болсон.

Байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой гомдол, мэдээллийг Цагдаагийн ерөнхий газрын 126 тусгай дугаарын утсаар болон Дотоодын цэргийн штабын веб сайт /www.intr.gov.mn/-аар хүлээн авч, шалган шийдвэрлэж байна.

Дотоодын цэргийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт "Дотоодын цэргийн командлагч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:" гээд 8.1.11 дэх заалтад "дотоодын цэргийн хүний нөөцийг сургаж бэлтгэх, нөхөн хангах ажлыг зохион байгуулах;" гэж зохицуулсны дагуу дотоодын цэргийн байгууллагад зохион байгуулах сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлдэг ба тухайн хөтөлбөрт хүний эрхийг хамгаалах чиглэлийн сургалт нь алба хаагчийн заавал судлах хичээлийн нэг болдог.

Дээрх сургалтын чанар, үр дүнд цагдаагийн төв байгууллагын сургалтын асуудал хариуцсан нэгж жил бүр тайлан хүлээн авч, үнэлгээ хийж ажиллаж байна.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

Дотоодын цэргийн байгууллагын амь хохирсон алба хаагчдын судалгаа													
Алба хаагчийн			Амь үрэгдсэн шалтгаан нөхцөл							Нэг удаагийн болон оршуулгын тэтгэмж			Мөнгөн дүн
д/д	Овог, нэр /Эхний үсэг/	Албан тушаал, цол	Огноо	Үйлдэгдсэн газар	Амьс хорлох	Өвчний улмаас	Албан үүрэг гүйцэтгэж байхдаа	Хангаарад өрсөн	Осолд өртсөн	Нэг удаагийн болон оршуулгын тэтгэмж олгосон эсэх			
Дотоодын цэргийн штаб													
1	А.Ц	Холбоо, мэдээллийн ахлах инженер, ахмад	2022.10.14	Баянзүрх дүүргийн 2 дугаар хороо цэргийн хотхон Дотоодын цэргийн штабын байр	Үйл явдлын талаарх мэдээлэл.		+			+	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан	83.600.000	
06 дугаар анги													
2	Х.А	Хамгаалалтын ажилтан, дэд ахлагч	2023.08.28	Чингэлтэй дүүргийн 2 дугаар хороо 21-ийн 5 муудалцаж, маргасны улмаас дугаар байр 3 дугаар орц 45 тоот	Ар гэр /найз охин/-тэйгээ гэрээ өөрийгөө боомилж амиа хорлосон.	+							
3	С.М	Хамгаалалтын ажилтан, дэд ахлагч	2023.12.02	Сонгинохайрхан дүүргийн 38 хорооны 50а байрны ертөнцийн зүгээр хойд талд	Найз охинтой маргалдсаны улмаас өөрийгөө боомилж амиа хорлосон.	+							
4	З.Н	Байлдагч	2022.06.17	Хуульчдын гудамж 15160-0019 тоот /Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг/	Ходоодны цочмог судалтын шалтгаант үхжигт, үрэвслийн улмаас ходоод урагдсан, хэвлийн хөндийн гялтгангийн түлэгдэл, идээт тархмал үрэвсэлээр хүндэрч нас барсан.		+			+	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан	22.233.989	
5	М.Б	Байлдагч	2024.05.30	Төв аймгийн Цээл сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт	Төв аймгийн Цээл сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт албан үүрэг гүйцэтгэж байхдаа зам тээврийн осолд орж нас барсан			+		+	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан	142.596.000	
805 дугаар анги													
6	М.Б	Эргүүлийн офицер, ахмад	2022.05.18	Хан-Уул дүүргийн 21 дүгээр хорооны нутаг байрлах Нийслэлийн эх хүүхдийн эрүүл мэндийн нэгдсэн төв	Зүрхний архаг цус хомсрох өвчний улмаас амьсгал зүрх судасны дутагдлаар нас барсан		+			+	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 4, 20 дугаар зүйлийн 1 хэсэгт заасан	48.000.000	
7	Б.А	Жолооч, ахлах ахлагч	2025.03.16	Сонгинохайрхан дүүргийн 39 дүгээр хороо, Овоотын 71-3а тоотод	Согуурсан үедээ хамтран амьдрагч Д.Н-тэй маргалдаж, цээжин тус газраа 1 удаа өөрийгөө хутгалж нас барсан.	+							
809 дүгээр анги													
8	Л.М	Хамгаалалтын ажилтан, дэд ахлагч	2025.11.20	Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 1 дүгээр баг, Цагаан давааны орчимд	Тээвэрлэлтийн хамгаалалтад үүрэг гүйцэтгэж байх хугацаандаа зам тээврийн ослын улмаас амь хохирсон.		+			+	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 4, 20 дугаар зүйлийн 1 хэсэгт заасан	296.616.120	

810 дугаар анги									
9	1	Н.П	Жолооч, дэд ахлагч	2023.05.10	Өмнөговь Цогтцэций Өгөөмөр 4-р баг	аймгийн сумын	Өөрийн гэртээ боомилсон байдалтай олдсон.	+	
10	2	Г.Г	Хамгаалалтын ажилтан, дэд ахлагч	2024.02.11	Өмнөговь Цогтцэций "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн "Цанхи" хотхонд	аймгийн сумын "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн "Цанхи" хотхонд	Өмнөговь аймгийн Цогтцэций сумын "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн "Цанхи" хотхонд амралтын гэртэй унтаад сэрээгүй нас барсан.	+	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 4, 20 дугаар зүйлийн 1 хэсэгт ззасан
822 дугаар тусгай салбар									
11	1	Б.Б	Хамгаалалтын ажилтан, ахлах ахлагч	2024.11.09	Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэгт	Дархан-Уул аймгийн Цус харвалтаас болж Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэгт хүргэж нас барсан		+	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 4, 20 дугаар зүйлийн 1 хэсэгт ззасан
834 дүгээр тусгай салбар									
12	1	Ө.А	Хамгаалалтын ажилтан, дэд ахлагч	2024.11.05	Төв аймгийн Сэргэлэн сумын Баянбурд 1-р баг, "Хоолтын даваа	Сэргэлэн хотоос Дорноговь аймаг явж байх үедээ зам тээврийн осолд орж, нас барсан.		+	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 4, 20 дугаар зүйлийн 1 хэсэгт ззасан

ДОТООДЫН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧДААС ЦЭРГИЙН ДҮРМИЙН БУСААР ХАРЬЦАХ ЗӨРЧИЛ ГАРГАСАН АЛБА ХААГЧДЫН СУДАЛГАА									
д/д	д/д	Овог, нэр /Эхний үсэг/	Алба хаагчийн		Зөрчил гаргасан огноо	Гаргасан зөрчил	Шалтгаан нөхцөл	Илрүүлсэн хэлбэр	Шийдвэрлэлт
			Албан тушаал, цол						
05 дугаар анги									
1	1	Н.Л	Хугацаат цэргийн алба хаагч, тасгийн захирагч, дэд түрүүч	Хугацаат цэргийн алба хаагч, тасгийн захирагч, дэд түрүүчтэй хувийн таарамжгүй харьцаанаас болж, нүүрэн тус газарт үйлдлийн улмаас учирч цохьсон.	2024.09.21	Хугацаат цэргийн алба хаагч, тасгийн захирагч, дэд түрүүчтэй хувийн таарамжгүй харьцаанаас өөрийн гаргасан үйлдлийн улмаас учирч болзошгүй эрсдэлийг	Ёс зүй, хариуцлага хангалттай төлөвшөөгүй, захирах, захирагдах зарчмыг чанд мөрдөөгүй, өөрийн гаргасан үйлдлийн улмаас учирч болзошгүй эрсдэлийг	Дотоод хяналтаар	Дэд түрүүч Н.Лхагасүрэнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 180 дугаар зарлигийн дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан "Цэргийн сахилгын дүрэм"-ийн 7.6.7 дахь заалтад "цэргийн цол хураах" сахилгын шийтгэл ногдуулж, гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйлдлийг нь шалгуулж шийдвэрлүүлэхээр 2024 оны 03/28 дугаар албан бичгээр харьяаллын дагуу Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн газрын нэгдүгээр хэлтэс рүү шилжүүлсэн.
2	2	А.М	Хугацаат цэргийн алба хаагч, салааны захирагчийн орлогч, түрүүч	Хугацаат цэргийн алба хаагчидтай дүрмийн зохион байгуулаагүй, бусаар харьцаж, биед нь халдсан	2025.12.23	Хугацаат цэргийн алба хаагчидтай дүрмийн зохион байгуулаагүй, бусаар харьцаж, биед нь халдсан	Ангийн өдөр тутмын үйл ажиллагааг цагийн хуваарийн дагуу удирдан зохион байгуулаагүй, хугацаат цэргийн алба хаагчийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сулруулсан	Цахим орчинд оруулсан иргэний мэдээлэл	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 180 дугаар зарлигаар баталсан "Цэргийн сахилгын дүрэм"-ийн 7 дүгээр зүйлийн 7.4 хэсэгт заасан сахилгын шийтгэлийг тус тус ногдуулж, гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйлдэлд Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн газрын нэгдүгээр хэлтэст мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.
		Т.Х	Хугацаат цэргийн алба хаагч, тасгийн захирагч, дэд түрүүч						
		Д.Ж	Хугацаат цэргийн алба хаагч, тасгийн захирагч, дэд түрүүч						
		Г.Д	Хугацаат цэргийн алба хаагч, тасгийн захирагч, дэд түрүүч						
806 дугаар анги									
3	1	Н.Б	Хугацаат цэргийн алба хаагч, тасгийн захирагч, дэд түрүүч	Хугацаат цэргийн алба хаагчидтай дүрмийн зохион байгуулаагүй, харьцаж суран бүсээр гар руу нь цохисон	2024.12.10	Хугацаат цэргийн алба хаагчидтай дүрмийн зохион байгуулаагүй, харьцаж суран бүсээр гар руу нь цохисон	Ёс зүй, хариуцлага хангалттай төлөвшөөгүй, хууль дүрмийн мэдлэг дутмаг	Дотоод хяналтаар	Хугацаат цэргийн алба хаагчдын үйл ажиллагаанд тавих хяналтыг сулруулсан салааны захирагч, дэслэгч С.Б-д Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.3 дахь заалтад заасан албан тушаалын цалингийн хэмжээг 1 сарын хугацаатай 20 хувиар бууруулах, дэд түрүүч Н.Б-д Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 180 дугаар зарлигийн дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан "Цэргийн сахилгын дүрэм"-ийн 7.6.7 дахь заалтад "цэргийн цол хураах" сахилгын шийтгэл ногдуулж, гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйлдлийг нь шалгуулж шийдвэрлүүлэхээр 2025 оны 04/17 дугаар албан бичгээр харьяаллын дагуу Баянзүрх дүүргийн цагдаагийн газрын хоёрдугаар хэлтэс рүү шилжүүлсэн.

ДОТООДЫН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭРҮҮЛ МЭНДЭЭРЭЭ ХОХИРСОН АЛБА ХААГЧИЙН СУДАЛГАА

Алба хаагчийн		Хохирсон шалтгаан нөхцөл			Шийдвэрлэлт
Овог, нэр /Эхний үсэг/	Албан тушаал, цол	Огноо	Үйлдэгдсэн газар	Үйл явдлын талаарх мэдээлэл	
Д/А					
Н.Э	Байлдагч	2023.12.09	Сонгинохайрхан дүүргийн 22 дугаар хороо Дотоодын цэргийн 05 дугаар анги	Найз охинтой үүссэн хувийн таарамжгүй харьцаанаас болж сулруулсан тус ангийн шуурхай удирдлагын жижүүр, цэргийн ротын захирагч, ангийн жижүүр, хариуцлагатай эрүүл нарт албан тушаалын цонхоор үсэрч амиа хорлохыг завдсан.	Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн газрын нэгдүгээр хэлтэс мөрдөн шалгах ажиллагаа явуулсан.